



САНГИЙН ЯАМ




ИРГЭДИЙН ТӨСӨВ

НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



Улаанбаатар хот 2020

Санал хүсэлтээ дараах хаягаар илгээнэ үү.

-  tusuv@mof.gov.mn
-  www.mof.gov.mn
www.iltod.gov.mn
-  Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр, Д корпус, Улаанбаатар 15160, Монгол Улс

**Монгол улсын нэгдсэн төсвийн
2019 оны нэгдүгээр улирлын
гүйцэтгэлийн мэдээ**



**Монгол улсын нэгдсэн
төсвийн 2019 оны хагас
жилийн гүйцэтгэлийн мэдээ**



**Монгол улсын нэгдсэн
төсвийн 2019 оны 3-р
улирлын гүйцэтгэлийн мэдээ**



2019 ОНД ЗАСГИЙН ГАЗРЫН БАРИМТАЛСАН БОДЛОГУУД

1. ТӨСВИЙН ОРЛОГО

Татварын хуулийн шинэчлэл, Гаалийн шинэчлэл, Орон нутгийн орлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх.

2. ТӨСВИЙН ЗАРЛАГА

Төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, үр ашигтай хуваарилахад технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ил тод байдлыг сайжруулах.

3. ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 5.4%-д хүргэх.

4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулах.

ЦАХИМ ИЛ ТОД ҮР АШИГТАЙ

5. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Гадаадын зээл, тусламжийг эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн үр ашигтай төсөлд зарцуулах.

6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Өрийн өнөөгийн үнэ цэнэ болон дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг 55.3% болгож, хүүгийн зардлыг бууруулах.

7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн төвлөрлийг сааруулж, орон нутгийн өмчийг эзэнд нь хариуцуулах замаар үр ашгийг хэмэгдүүлэх

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр УИХ баталсан нь 4-р улирлын онцлог байлаа.



2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ **-756.2 тэрбум**


Тэнцвэржүүлсэн орлого төлөвлөгөөнөөс давснаар төсвийн алдагдал батлагдсан дүнгээс 3 дахин бага гүйцэтгэлтэй гарч, ДНБ-ий 5,4%-д хүрэх төлөвлөгөөг давуулан биелүүлж 1,6%-д хүргэлээ.

✓
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН
ОРЛОГО
10,905.5 ТЭРБУМ

✓
ТӨСВИЙН ЗАРЛАГА
11,661.7 ТЭРБУМ

ТӨСВИЙН ОРЛОГЫН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогоос тодорхой хэсгийг Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилж, үлдсэн орлого болох төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор төсвийн зарлагыг санхүүжүүлдэг.



Төсвийн нийт орлого

12,040.3
тэрбум



Импортоос хамаарах орлого

2,875.9
тэрбум
төгрөг

Гадаад валютын ханш өссөн нь импортын орлого давахад нөлөөлсөн



Иргэдийн хөдөлмөр эрхлэлтээс төвлөрүүлсэн орлого

2,727.8
тэрбум
төгрөг

НДС орлого 289 тэрбум төгрөгөөр давсан



Уул уурхайн салбарын орлого

3,138.5
тэрбум
төгрөг

2019 оны 1 сард өмнөх оны АМНАТ-ийн дутуу 166 тэрбум төгрөг төлөгдсөн



Бусад орлого

3,298.1
тэрбум төгрөг

Ирээдүйн өв сан нь эрдэс баялгаас бий болсон орлогын тодорхой хэсгийг ирээдүй хойч үедээ зориулан хадгалж буй сан юм.

1,040.2
тэрбум

Ирээдүйн өв сан

Төсвийн тогтворжуулалтын сан нь гол нэр төрлийн эрдэс, түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс хамаарсан төсвийн орлогын хэлбэлзлийг тогтворжуулах, мөн төсвийн алдагдлыг нөхөх зориулалттай сан юм.

94.6
тэрбум

Төсвийн тогтворжуулалтын сан


10,905.5
тэрбум



Тэнцвэржүүлсэн орлого

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГЫН ЗАДАРГАА

✓ ● Орлогын албан татвар	2,555.7	тэрбум
● Татварын бус орлого	1,092.3	тэрбум
✓ ● Нийгмийн даатгалын шимтгэлийн хураамж	2,030.5	тэрбум
✓ ● Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,486.3	тэрбум
✓ ● Бусад татвар	2,740.7	тэрбум



төлөвлөгөөнөөс давсан орлого




орлого төлөвлөгөөнөөс давсан шалтгаан

2019 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОХ ОРЛОГО



УУЛ УУРХАЙН ГОЛЛОХ ЭКСПОРТЫН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол банканд тушаасан хэмжээ



Нүүрсний хамгийн том экспортлогч болох "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн экспортын нүүрсний хэмжээ 13.7 сая тоннд хүрч, өмнөх онтой харьцуулахад 17.7 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

Оюу толгойн ил уурхайн гарц буурч байгаатай холбогдуулан өмнөх оны мөн үеэс ээсийн баяжмалын экспорт бага зэрэг буурсан үзүүлэлтэй байна.

Төмрийн хүдэр, баяжмалын гол экспортлогч болох "Болдтөмөр ерөө гол" ХХК-ийн экспортлосон төмрийн хүдэр, баяжмалын хэмжээ 3.4 сая тоннд хүрч, өмнөх оноос 0.5 сая тонноор нэмэгдсэн бол "Дархан төмөрлөг" ТӨҮГ-ын экспорт 1.5 сая тоннд хүрч, өмнөх оноос мөн 0.5 сая тонноор нэмэгдсэн нь ийнхүү төмрийн хүдэр, баяжмалын экспорт нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ

ТАТВАРЫН ТОГТОЛЦООГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЛЭЭ.

“Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх конвенц”-д нэгдэж **135** дах гишүүн орон боллоо.



Сангийн сайд 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр “Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх конвенц”-д гарын үсэг зурлаа.



Татварын ил тод байдлын олон улсын стандартыг нэвтрүүлж, “Глобал форум”-ын гишүүн болов.



Татвараас зайлсхийхийн эсрэг олон улсын стандартуудыг нэвтрүүлж, “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийг эсрэг BEPS”-ийн гишүүн болов.



Дэлхийн 135 улс, оффшор бүстэй татварын зорилгоор мэдээлэл солилцох боломж бүрдэв.

УИХ-аас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан татварын багц хууль нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэллээ.

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ТАНД:

- ✓ 300 сая хүртэлх орлоготой бол 1 хувийн орлогын татвар төлнө.
- ✓ 1.5 тэрбум хүртэлх орлоготой бол төлсөн орлогын татварын 90%-ийг буцаан авна.
- ✓ 6 тэрбум төгрөгөөс бага ашигтай бол жилд 2 удаа орлогын татварын тайлан гаргана.
- ✓ 50 сая төгрөг хүртэл орлоготой бол хялбаршуулсан горимоор орлогын 15%-ийн татвар төлж жилд 1 тайлан гарган боломжтой.
- ✓ 25 хувийн татвар төлөх ашгийн босгыг 2 дахин нэмэгдүүлж 6 тэрбум болсон.
- ✓ Тайлангаа 1 жилийн хугацаанд засварлах боломжтой.
- ✓ Алслагдсан аймагт бизнес эрхэлдэг бол 90% хүртэл орлогын албан татварын хөнгөлөлт эдэлнэ.

ИРГЭН ТАНД:

- ✓ НӨАТ-ын урамшууллыг улирал бүр буцаан олгоно.
- ✓ Хувиараа бичил ажил, үйлчилгээ эрхлэгчид тайлан гаргахгүйгээр тогтмол татвар төлнө.
- ✓ Хувиараа жижиг бизнес эрхлэгчид хялбаршуулсан горимоор татвараа тайлагнаж, төлөх боломжтой.
- ✓ Орон сууц анх удаа худалдан авсан иргэнд 6 сая төгрөгийн татварын буцаалт олгоно.
- ✓ 8%-иас дээш хүүтэй орон сууцны зээл авсан иргэдэд татварын хөнгөлөлт эдэлнэ.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн орлогын албан татвараас бүрэн чөлөөлнө.
- ✓ Алслагдсан орон нутагт хувиараа бизнес эрхлэгчид 90% хүртэл орлогын татварын хөнгөлөлт эдэлнэ.



БИЗНЕС ЭРХЛЭЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИНЭ

ИРГЭДИЙН АМЬЖИРГАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИНЭ

ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Улсын хэмжээнд гаалийн шинэчлэлийн ажлууд хийгдэж эхлээд байна



Алтанбулаг, Замын-Үүд, Гашуунсухайт зэрэг боомтуудыг шинэчлэх бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээ



Өндөр хүчин чадлын рентген тоног төхөөрөмж худалдан авч эхэллээ



Тээврийн хэрэгслээс автоматаар дээж авч ашигт малтмалын чанар, агуулга тодорхойлох тоног төхөөрөмж худалдан авч эхэллээ



Олон улсад итгэмжлэгдэх гаалийн төв ба салбар 5 лабораторийг барьж байгуулж байна.




Хар тамхи илрүүлэх орчин үеийн тоног төхөөрөмжөөр гаалийн байгууллагыг хангалаа



Тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх “ухаалаг гарц”, телехяналтын систем бүхий шуурхай удирдлагын төвүүдийг байгуулна



ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ҮР ДҮНД



Хилийн боомтуудын олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх



Иргэд гаалийн байгууллагаар түргэн шуурхай, саадгүй үйлчлүүлэх боломжоор хангах



Экспортолж буй байгалийн баялгаасаа татварыг бүрэн хураах




Хууль бус, чанарын шаардлага хангахгүй бараа нэвтрүүлэхээс сэргийлж иргэдийн эрх ашгийг хамгаалах

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын нэгдсэн төсвийн жилийн гүйцэтгэл



ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТАЛСАН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ:

Зарлагын оновчтой, үр ашигтай хуваарилалт чиглэлээр:

- Өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр ашиглалттай холбоотой урсгал зардлыг орон нутагт хариуцуулав.
- Орон нутгийн төсвийн суурь зардал тооцох аргачлалыг шинэчлэн зардлын норм, нормативыг төсвийн байгууллагуудын хэрэгцээ шаардлага, онцлогт нь нийцүүлж оновчтой хуваарилдаг болов.
- Орон нутаг дахь соёл, урлаг, спортын чиг үүргийг тухайн орон нутаг бие даан хэрэгжүүлдэг боллоо.
- Урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлдэггүй байхаар журамлав.

Орлоготой нь уялдсан зардлын төлөвлөлт чиглэлээр:

- Байгаль орчныг хамгаалах чиг үүргийг холбогдох орлогын хамт орон нутагт шилжүүлэв.
- Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, устгахад хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоо бүрэн зарцуулах эрхийг тухайн орон нутгийн хот тохижуулах газарт олгов.
- Авто замын санд төвлөрөх орлогыг авто замын засвар, арчлалтын ажилд бүрэн шилжүүлснээр авто замын арчлалт засвар үйлчилгээний ажлын чанар, үр дүн, гүйцэтгэл сайжрах боломж бүрдэв.

Үр ашигтай удирдлагын менежмент чиглэлээр:

- Байнгын давтамжтай олгогддог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг ерхийн мэдээллийн санг түшиглэн улсын төсвөөс нэгдсэн зохицуулалтын хүрээнд олгодог болсноор төсвийн сахилга бат сайжрав.
- Мал эмнэлгийн үйл ажиллагаа, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тандалт судалгааны арга хэмжээний төсвийг үр ашигтай байдлаар хуваарилж эхлэв. хэрэгжүүллээ.

Цахим бүртгэл, хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр:

- Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг туршин, нэвтрүүлж эхэллээ.
- Эрүүл мэндийн даатгалын цахим системийг нэвтрүүлэв.

Хэрэглээний зардлын хэмнэх чиглэлээр:

- Эрүүл мэнд, онцгой байдал, хил хамгаалах, цагдаа зэрэг байгууллагуудаас бусад төрийн байгууллагын албан хэрэгцээндээ ашиглаж байгаа автомашиныг шатахууны нормыг шинэчлэн тогтоож, төрийн албаны автомашинд ялгах тэмдэг хэрэглэдэг боллоо.
- Төрийн байгууллагын албан бичиг хэрэг хөтлөлт, боловсруулалт, шийдвэрлэлтийг цахимжуулж эхэллээ.


Эрүүл мэндийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний багцын нэр төрөл, санхүүжилтийн тарифыг нэмэгдүүлснээр иргэн эрүүл мэндийн даатгалын үр шимийг оршин суугаа сум орон нутагтаа хүртэх боломжтой болов.
- Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг болон Арьсны өвчин судлалын үндэсний төвд батлагдсан төсвийн зарцуулалтын эрх мэдлийг бүрэн олгосноор өрсөлдөөнд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээг чанар болон гүйцэтгэлийн үр дүнгээр нь тооцон санхүүжүүлж эхлэв.

УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

НИЙТ 9,091.9 ТЭРБУМ ТӨГРӨГ


- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
1,561.2 ТЭРБУМ ТӨГРӨГ 16.8%
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
1,737.8 ТЭРБУМ ТӨГРӨГ 18.7%
- Эрүүл мэндийн сайд
823.0 ТЭРБУМ ТӨГРӨГ 8.9%
- Хууль зүй, дотоод хэргийн сайд
536.5 ТЭРБУМ ТӨГРӨГ 5.8%
- Батлан хамгаалахын сайд
250.3 ТЭРБУМ ТӨГРӨГ 2.7%
- Монгол Улсын Ерөнхий сайд
298.7 ТЭРБУМ ТӨГРӨГ 3.2%
- Зам, тээврийн хөгжлийн сайд
235.6 ТЭРБУМ ТӨГРӨГ 2.5%
- Бусад
1,408.1 ТЭРБУМ ТӨГРӨГ 15.1%
- Сангийн сайд
2,443.9 ТЭРБУМ ТӨГРӨГ 26.3%



Сангийн сайдын зарлагын дүнг задалж харвал:



Орон нутагт олгох дэмжлэг



ЖИЛИЙН НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ 673.6 ТЭРБУМ

ЦАЛИНТАЙ ЭЭЖ ХӨТӨЛБӨР

100.2
тэрбум ₮

14.9%
Нийгмийн халамжийн
сангийн зардалд эзлэх хувь

0-3 насны хүүхэд асрахад сар бүр **50,000 ₮**

0-18 насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд улирал бүр **320,000 ₮**

ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ

35.8
тэрбум ₮

5.3%
Нийгмийн халамжийн
сангийн зардалд эзлэх хувь

Том хүнд сар бүр **16,000 ₮**


Хүүхдэд сар бүр **8,000 ₮**

ХҮҮХДЭД ОЛГОХ МӨНГӨН ТЭТГЭМЖ

229.6
тэрбум ₮

34.1%
Нийгмийн халамжийн
сангийн зардалд эзлэх хувь

Хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд сар бүр **20,000 ₮**



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР

111.6
тэрбум ₮

16.7%
Нийгмийн халамжийн
сангийн зардалд эзлэх хувь

2019 оны 2-р сарын 1-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэн.
Тэтгэвэр **155,000-аас 174,000 ₮**
Тэтгэмж **70,000-аас 76,000 ₮**

НӨХЦӨЛТ МӨНГӨН ТУСЛАМЖ

47.7
тэрбум ₮

7.1%
Нийгмийн халамжийн
сангийн зардалд эзлэх хувь

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.3-д заасан хувь хэмжээгээр 76,400 гаруй иргэнд

БУСАД

118.7
тэрбум ₮

17.6%
Нийгмийн халамжийн
сангийн зардалд эзлэх хувь

АЛДАРТ ЭХИЙН ОДОНТОЙ ЭХЧҮҮДЭД ОЛГОХ ТЭТГЭМЖ

29.3
тэрбум ₮

4.3%
Нийгмийн халамжийн
сангийн зардалд эзлэх хувь

I-р одонтой ээжид жилд 1 удаа **200,000 ₮**


II-р одонтой ээжид жилд 1 удаа **100,000 ₮**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН



Эрүүл мэндийн даатгалын сангийн **2019** оны жилийн гүйцэтгэл **351.0 тэрбум** төгрөг байна. Үүнээс **67.5%** буюу **236.8 тэрбум** төгрөгийг улсын хэвшлийн эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлсэн даатгуулагчдад үзүүлэх хөнгөлөлт буюу Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд өгөх шилжүүлэгт зарцуулсан бол эмийн үнийн хөнгөлөлтөд **33.4 тэрбум** төгрөг зарцуулжээ.

УЛСЫН ЭМНЭЛГҮҮДЭД ӨГӨХ ШИЛЖҮҮЛЭГ



ХУВИЙН ЭМНЭЛГҮҮДЭД ӨГӨХ ШИЛЖҮҮЛЭГ



ОНЦЛОХ ЗАРДЛУУД



ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ



“ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” ХӨТӨЛБӨР




2017 ОНД ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ:

- В, С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээнд хамрагдсан: **1 сая даатгуулагч**
- Идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдсан: **98.7 мянган даатгуулагч**
- Эмийн үнийн хөнгөлөлт эдэлсэн: **21.1 мянган даатгуулагч** (С вирус) **14.6 мянган даатгуулагч** (В вирус).

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага **407.6 тэрбум** төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс **350.9 тэрбум** төгрөгийг зарцуулсан бөгөөд **56.7 тэрбум** төгрөг хэмнэгдэж, зардлын гүйцэтгэл **86.1%** байна.



ХЭМНЭГДСЭН ЗАРДЛУУД:



- ✓ Хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлэх даатгуулагчийн зардал
- ✓ Элэгний В,С вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт
- ✓ Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний зардал
- ✓ “Элэг бүтэн Монгол хөтөлбөр”
- ✓ Элэгний В,С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээний зардал
- ✓ Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, асаргаа, сувилгаа, оношлогоо, шинжилгээний зардал
- ✓ Бусад

ЭМДСАНГИЙН ХЭМНЭЛТЭД НӨЛӨӨЛСӨН ГОЛЛОХ ХҮЧИН ЗҮЙЛС:



“Эрүүл мэндийн даатгалын цахим систем”-ийн хүрээнд даатгуулагчийн хурууны хээний бүртгэлийг нэвтрүүлсэн.

Элэгний В, С вирусийн эм бичих эрх бүхий эмч нарыг хурууны хээний бүртгэлтэй холбосон.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээг хийж буй нийслэлийн 24 лабораторийг шалгаж 15 лабораторийн даатгалын гэрээг түр зогсоосон.

Элэгний вирусийн идэвхжилтэй байсан хүмүүс 2017 оноос “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт идэвхтэй хамрагдаж эрүүл мэндийн байдал сайжирснаар эмийн үнийн хөнгөлөлтийн зардал хэмнэгдэж байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

Нийгмийн даатгалын сангийн зардал **99.7** хувийн гүйцэтгэлтэй буюу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар **2,062.3 тэрбум** төгрөгийн зарцуулалттай байна.

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН

1,839.2 тэрбум төгрөг

- Өндөр настны тэтгэвэр **1,396.9 тэрбум ₮**
- Тахир дутуугийн тэтгэвэр **230.9 тэрбум ₮**
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр **71.5 тэрбум ₮**
- Цэргийн тэтгэвэр **139.4 тэрбум ₮**

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

43.6 тэрбум төгрөг

- Ажилгүйдлийн тэтгэмж **43.6 тэрбум ₮**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

24.5 тэрбум төгрөг

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН

124.2 тэрбум төгрөг

- Жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж **90.2 тэрбум ₮**
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж **19.9 тэрбум ₮**
- Оршуулгын тэтгэмж **14.0 тэрбум ₮**

ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САН



30.8 тэрбум төгрөг

- ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж **28.9 тэрбум ₮**
- Тахир дутуу даатгуулагчийн сувиллын газрын зардал **0.9 тэрбум ₮**
- ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ **1.0 тэрбум ₮**

Бүх төрлийн тэтгэврийг инфляцийн түвшинтэй уялдуулж нэмэгдүүлсэн.

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2019 оны төсөвт улсын болон концессын нийт **1,698.1 тэрбум** төгрөгийн **1,293** хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгаж баталсан. Үүний **31.4 хувь** нь он дамжин хэрэгжих, **68.4 хувь** нь 2019 онд шинээр хэрэгжих төслүүд юм. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн болгож,

<https://publicinvestment.gov.mn/>



вeб хуудас болон гар утасны “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшныг ашиглалтад орууллаа.




Санхүүжилтийн үйл ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэх

Иргэд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах

Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх

Гүйцэтгэгч аж ахуй нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах

Иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах



САНХҮҮЖИЛТИЙГ АЖЛЫН 1-3 ХОНОГТ БАГТААН ШИЙДВЭРЛЭДЭГ БОЛСОН.

Санхүүжилтийг саадгүй, түргэн шийдвэрлэдэг болсноор 2019 онд **1293** төсөл хэрэгжиж, нийгмийн хэрэгцээтэй бүтээн байгуулалтууд хийгдлээ.

2019 ОНД АШИГЛАЛТАД ОРСОН



Гаалийн шинэчлэл төслийг хэрэгжүүлж байна.



Боловсролын хүртээмжийг нэмэгдүүллээ.



Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах дэд бүтцийн төслүүд хэрэгжиж байна.





Эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд ойр байлгах, эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулж байна.

2019 онд төсвийн хөрөнгө оруулалтаар түүхэндээ анх удаа 1.6 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдлээ.


Засгийн газрын өрийн 2019 оны гүйцэтгэл



Монгол Улсын Засгийн газар 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар өрийн үндсэн төлбөрт 603.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 894.5 тэрбум төгрөг, нийт 1,498.0 тэрбум төгрөг төлжээ.



Засгийн газрын өрийн эдийн засагт үзүүлэх дарамт буурч байна.



ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



2019 оны төсөвт **1,096.3 тэрбум** төгрөгийн гадаад зээл, **146.0 тэрбум** төгрөгийн гадаад тусламжаар нийт **132** төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгаж, баталсан. 2019 оны 4-р улирлын эцсийн байдлаар дараах нийгэмд шаардлага хэрэгцээтэй томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн байна.



21.9

тэрбум төгрөг

**ТАЙШИР-АЛТАЙ УС
ХАНГАМЖ ТӨСӨЛ**



20.3

тэрбум төгрөг

**ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН УР
ЧАДВАРЫГ
САЙЖРУУЛАХ
ТӨСӨЛ**



40.5

тэрбум төгрөг

**БАРУУН БҮСИЙН
БОСОО ТЭНХЛЭГИЙН
АВТО ЗАМЫГ
ХӨГЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ХӨТӨЛБӨР**



61.2

тэрбум төгрөг

**УЛААНБААТАР ХОТЫН
ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР**



35.0

тэрбум төгрөг

**ЗЭЭЛИЙН БАТАЛГААНЫ
СИСТЕМИЙГ
БҮРДҮҮЛЭХ ЗАМААР
ЭДИЙН ЗАСГИЙГ
ТӨРӨЛЖҮҮЛЭХ,
АЖЛЫН БАЙРЫГ БИЙ
БОЛГОХ ТӨСӨЛ**



53.0

тэрбум төгрөг

**БҮС НУТГИЙН АВТО
ЗАМЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ЗАМ ЗАСВАРЫН
ТӨСӨЛ**



88.4

тэрбум төгрөг

**УЛААНБААТАР
ХОТЫН ШИНЭ ОЛОН
УЛСЫН НИСЭХ
ОНГОЦНЫ БУУДАЛ
БАРИХ ТӨСӨЛ**



80.8

тэрбум төгрөг

**ТӨСӨВ, САНХҮҮГИЙН
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ДЭМЖИХ
ТӨСӨЛ**



22.7

тэрбум төгрөг

**ҮНДЭСНИЙ
ОНОШЛОГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГУУЛАХ ТӨСӨЛ**



54.0

тэрбум төгрөг

**УЛААНБААТАР
ХОТЫН АГААРЫН
ЧАНАРЫГ
САЙЖРУУЛАХ
ХӨТӨЛБӨР**



43.1

тэрбум төгрөг

**БАЯНХОНГОР-
БАЙДРАГИЙН ГҮҮР
ЧИГЛЭЛИЙН 129.4
КМ АВТОЗАМ БАРИХ
ТӨСӨЛ**



88.8

тэрбум төгрөг

**УЛААНБААТАР-
МАНДАЛГОВЬ
ЦАХИЛГААН
ДАМЖУУЛАХ АГААРЫН
ШУГАМ, ДЭД СТАНЦ
БАРИХ ТӨСӨЛ**



88.0

тэрбум төгрөг

**УЛААНБААТАР-
ХӨШИГИЙН
ХӨНДИЙН ШИНЭ
НИСЭХ ОНГОЦНЫ
БУУДЛЫН ХУРДНЫ
ЗАМ БАРИХ ТӨСӨЛ**



20.1

тэрбум төгрөг


**ШИНЭ ЗУУНЫ
БОЛОВСРОЛ ТӨСӨЛ**



56.3

тэрбум төгрөг

**ГАЧУУРТЫН
УУЛЗВАРААС
НАЛАЙХ-ЧОЙРЫН
УУЛЗВАР ХҮРТЭЛХ
20.9 КМ АВТО ЗАМ
БАРИХ ТӨСӨЛ**



48.8


тэрбум төгрөг

**ЗАМЫН
ЦАГДААГЫН
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
УУЛЗВАРТ ГҮҮРЭН
ГАРЦ БАЙГУУЛАХ
ТӨСӨЛ**


ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



ЗАСГИЙН ГАЗРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУДААР:



УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦАА





Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2019 оны гүйцэтгэл




2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан нийт **138.6 тэрбум** төгрөгийг орон нутгийн төсөвт шилжүүлсэн ба **96.4** хувийн гүйцэтгэлтэй байна.

*Дүн (тэрбум төгрөг)



Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилтийг харвал:



*батлагдсан дүн

